



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/108/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Э.РАВЖААДЭЛГЭРЭХ ТАНАА

2022.02.25 № 142

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯА

009020252



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>59,500.00</u>	<u>363,280.00</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>3,765,800,541.59</u>	<u>3,754,980,312.51</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>3,765,860,041.59</u>	<u>3,755,343,592.51</u>
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>3,765,860,041.59</u>	<u>3,755,343,592.51</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>3,765,860,041.59</u>	<u>3,755,343,592.51</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	<u>183,601,300.00</u>	<u>302,327,800.00</u>
	Үйл ажиллагааны зардлын дүн	<u>202,114,852.86</u>	<u>320,315,929.08</u>
	Үйл ажиллагааны үр дүн	<u>(18,513,552.86)</u>	<u>(17,988,129.08)</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>(18,513,552.86)</u>	<u>(17,988,129.08)</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,784,373,594.45	3,765,860,041.59
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		7,471,680.00
	Тайлант оны үр дүн	(18,513,552.86)	(17,988,129.08)
	Эцсийн үлдэгдэл	<u>3,765,860,041.59</u>	<u>3,755,343,592.51</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>183,601,300.00</u>	<u>302,545,039.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>181,408,100.00</u>	<u>299,545,039.00</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>2,193,200.00</u>	<u>3,000,000.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(2,193,200.00)</u>	<u>(3,000,000.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	-	-
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<u>154,160,200.00</u>	<u>146,229,997.11</u>
	Урсгал зардал	154,160,200.00	146,229,997.11
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	<u>154,160,200.00</u>	<u>146,229,997.11</u>
	Орон нутгийн төсвөөс	154,160,200.00	146,229,997.11
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэн Дархан хотын иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан төрийн үйлчилгээний шуурхай байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэн бүрийн сэтгэл ханамжийг бий болгоход оршино.

- ✓ Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах
- ✓ Төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- ✓ Хотын байгаль экологийн тэнцвэртэй байдал, экологид суурилсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
- ✓ Тохижилт , ногоон байгууламж, реклам чимэглэл, мэдээллийн байгууламж, хог хаягдлын ажлын менежментийг сайжруулж иргэдийн ая тухтай амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх
- ✓ Гэр хорооллын нөхцөлийг хөгжүүлэх замаар гэр хорооллын дахин төлөвлөлтийн бодлого, төслийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх
- ✓ Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, тэдний мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, албан ажлын соёл ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл хоёр хувиар нэмэгдсэн.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 43,424.7 мянган төгрөгийн 86 нэр төрлийн хөрөнгө, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 15 нэр төрлийн 14,582.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй болон улсын бүртгэлийн гэрчилгээнд 691,913.2 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдалд дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 552.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 552.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

1. Зөв үе ногоон дэлхий ТББ -иас 150.0 мянган төгрөгийн НБББББ-ийг мэргэжлийн бус байгууллагаас орлого авсан, гэрээг дүгнэж ажиллаагүй байна.. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэж заасантай нийцэхгүй байна.
2. Тайлант хугацааны татвар төлөлтийн тайланг тулган шалгахад 2021 онд 402,725.60 төгрөгөөр дутуу төлөлтийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” ,НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;гэсэн тус тус заалт,"Тасалбар болголт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	552.7	-	-	-	-	-	-	2	557.7
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	2	552.7	-	-	-	-	-	-	2	557.7